“Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын даргын
2023 оны 03 дугаар сарын 31 –ний өдрийн А/07
дугаар тушаалын 24 дугаар хавсралт

1118269620
АТА2084 5761468

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг шинэчлэн баталсантай холбогдуулан шинэчлэн боловсруулсан.

☐ Нийслэлийн Засаг даргын захирамж, Газрын захирлын тушаалаар байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон.

Холбогдох хууль тогтоомжийн огноо: Нийслэлийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/156 дугаар захирамж

Дагаж мөрдөх огноо: 2023.04.01

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: 2023.03.31

| 1. Байгууллагын нэр | 2. Нэгжийн нэр |
|---|---|
| “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГазар | Тохижилт үйлчилгээний алба |
| **Албан тушаалын нэр:**<br>Жолооч | **Албан тушаалын ангилал**<br>**Зэрэглэл:**<br>ТҮ-3 |
| **Ажлын цаг:**<br>8/40 | **Ажлын байрны албан ёсны байршил:**<br>Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 32-р хороо, Хүй долоон худаг |
| **Хөдөлмөрийн нөхцөл:**<br>Хэвийн | **Онцгой нөхцөл:**<br>Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ:

**Албан тушаалын зорилго:**

Байгууллагын машин техник тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хариуцах, замын хөдөлгөөний аюулгүй байдлын дүрмийг сахих, тохижилт үйлчилгээний ажилд оролцох.

**Албан тушаалын зорилт:**

1. Байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад машин техникээр үйлчлэх, хариуцсан техник хэрэгслийг хамгаалах, бүрэн бүтэн байдлыг хариуцах, тохижилт үйлчилгээний ажилд оролцох.
2. Бусад

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага оролцооны хэлбэр<br>Туслах-Т<br>Хариуцан гүйцэтгэх-Г<br>Хянах-Х<br>Шийдвэрлэх-Ш |
|---|---|---|---|
| | 1. Өөрийн хариуцан эзэмшиж байгаа тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, засвар үйлчилгээг нэн даруй хийлгэж байх.<br>2. Замын хөдөлгөөнд холбогдох | **Хэрэгжилт хангагдсан байна.** | **Г** |

| | | | |
|---|---|---|---|
| **1 дүгээр зорилтын хүрээнд** | дүрэм, журмыг баримтлан оролцох<br>3. Сар бүрийн шатахууны тооцоог гаргаж, жолоочийн замын хуудсыг хөтлөн тухай бүрд нь захиргаа санхүүгийн албанд хүргүүлэх<br>4. Байгууллагын данстай тээврийн хэрэгслийг ажил дуусмагц автогражид байрлуулж, хариуцсан сахиулд хүлээлгэн өгөх<br>5. Автомашины эвдрэл гэмтэл гарсан үед техникийн комисст мэдэгдэж дүгнэлт гаргуулан нэн даруй арга хэмжээг авах<br>6. Тохижилтын ажил үйлчилгээнд шаардлагатай эд хөрөнгө, тоног төхөөрөмжийг заасан ажлын байранд зөөж тээвэрлэн хүргэх<br>7. Үндэсний их баяр наадам, бусад тэмдэглэлт баяр наадмын өдрүүдийн үйл ажиллагаа дуусмагц эд хөрөнгө, бараа материал, тоног төхөөрөмжийг зөөж тээвэрлэн агуулахад буцаан хураах<br>8. Өөрийн дураар автомашиныг хувийн ажилд ашиглахыг хатуу хориглоно. | Хэрэгжилт хангагдсан байна.<br>Хэрэгжилт хангагдсан байна.<br>Тухай бүрд арга хэмжээ авч ажилласан байна.<br>Хэрэгжилт хангагдсан байна.<br>Хэрэгжилт хангагдсан байна.<br>Зөрчил дутагдалгүй ажилласан байна. | Г<br>Г<br>Т<br>Т<br>Т<br>Г |
| **2 дугаар зорилтын хүрээнд** | 1. Өөрийн буруугаас шалтгаалан байгууллагын эд хөрөнгөнд хохирол учруулсан тохиолдолд хохирлыг эзэмшигч бүрэн хариуцах<br>2. Удирдах албан тушаалтнаар замын хуудас, шатахууны зарцуулалтад гарын үсэг зуруулан баталгаажуулж санхүүгийн тооцоог гарган захиргаа, санхүүгийн албанд гарган өгөх<br>3. Удирдах албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тээврийн хэрэгслийг бусдад шилжүүлэх, хувийн хэрэгцээнд ашиглахыг хориглоно.<br>4. Баяр ёслолоор болон цаг үеийн шаардлагатай тохиолдолд уртасгасан цагаар ажиллах<br>5. Хүй долоон худгийн ажил үүргээс шалтгаалсан мэдээ мэдээллийг нэн даруй шуурхай зохион байгуулан ажиллах<br>6. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас зохион байгуулж буй цаг үеийн холбогдолтой ажлуудад идэвхтэй оролцох<br>7. Автомашиныг шаардсан үед нь бэлэн байлгана. | Зөрчил дутагдалгүй ажилласан байна.<br>Хэрэгжилт хангагдсан байна.<br>Зөрчил дутагдалгүй ажилласан байна<br>Хэрэгжилт хангагдсан байна.<br>Хэрэгжилт хангагдсан байна.<br>Хэрэгжилт хангагдсан байна.<br>Хэрэгжилт хангагдсан байна. | Г<br>Г<br>Г<br>Т<br>Т<br>Т<br>Т |

| | | | |
|---|---|---|---|
| **3 дугаар зорилтын хүрээнд** | 1. Ёс зүйн дүрэм сахилга хариуцлага захирах захирагдах ёсыг баримтлан ажиллах<br>2. Удирдлагаас хариуцуулсан бусад ажлыг зохион байгуулж тайлагнах<br>3. Шаардлагатай тохиолдолд сэлгэн ажиллах<br>4. “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтын дагуу Үндэсний их баяр наадмаар ажиллах. | Ёс зүйн дүрмийн хэрэгжилт хангагдсан байна.<br>Хэрэгжилт хангагдсан байна.<br>Дүрмээр хүлээсэн үүрэг хангагдсан байна. | Г<br>Т<br>Т |

## III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

| | |
|---|---|
| **Боловсрол** | Бүрэн дундаас дээш боловсролтой байх |
| **Мэргэжил** | Жолооч /B, C, Д ангиллын үнэмлэхтэй байх |
| **Мэргэшил** | Мэргэшсэн жолоочийн сургалтанд хамрагдсан байх |
| **Туршлага** | Мэргэжлээрээ 3-аас дээш жил ажилласан |
| **Ур чадвар** | - Машин техникийн анхан шатны оношлогоо, засвар хийх чадвартай<br>- Нягт нямбай, хичээнгүй зан чанартай<br>- Багаар ажиллах чадвартай<br>- Хувийн зохион байгуулалт сайтай<br>- Нууц хадгалах |

## IV. АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

| | |
|---|---|
| **Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалтны нэр:**<br>Газрын дарга<br>Тохижилт үйлчилгээний албаны дарга | |
| **Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:**<br>Байхгүй<br>- | **Бусад харилцах субъект:**<br>1. Хамтран ажиллаж буй гэрээт байгууллага болон хувь хүн |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг баталсан: |
|---|---|
| “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын Хүний нөөц хариуцсан мэргэжилтэн:<br>А.Цэнгэлсайхан ..................... А.Цэнгэлсайхан<br>2023 оны 08 дугаар сарын 31 өдөр | “Монгол наадам цогцолбо” ОНӨТҮГ-ын Дарга<br>..................... С.Сайнбаяр<br>(Тамга, тэмдэг)<br>2023 оны 03 дугаар сарын 31 өдөр |